

Бодлогын зөвлөмж:

Тогтвортой Хөгжлийн Зорилгуудад хүрэхэд
энтрепренер залуучуудын ногоон болон
нийгмийн бизнесийн загварыг урамшуулан
дэмжих нь



Агуулгын хуудас

Товч танилцуулга	3
Танилцуулга	4
Нийгмийн болон ногоон бизнесийг тодорхойлох нь	6
Нийгмийн болон ногоон энтрепренершипт тулгарч буй саад, бэрхшээлүүд	7
ҮВІ ногоон болон нийгмийн энтрепренершипийн багц хэрэглэгдэхүүн	9
Монгол улсын тухай товчхон	10
Хөгжлийн Шийдэл ТББ-ын ногоон болон нийгмийн энтрепренершипийн багц хэрэглэгдэхүүнтэй туршилтын сургалт	12
Кейс судалгаа: Эрдэнэбаярын Аръяабазарын санаачилга	14
Зөвлөмж	16

Товч танилцуулга

Ногоон болон нийгмийн энтрепренер залуучууд бол өөрчлөлтийн төлөөлөгч, манлайлагчид бөгөөд эдийн засгийн шинэ боломжууд болон байнгын ажлын байруудыг бүтээдэг.

Дэлхийн Эдийн Засгийн Форумын мэдээлснээр дэлхийд 10 сая орчим нийгмийн энтерпрайзууд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жил бүр ойролцоогоор 2 их наяд ам.долларын орлого олж, бараг 200 сая ажлын байр бий болгож байна. Энэхүү үр дүнг бий болгож буй бизнесүүд нь дэлхийн эдийн засгийн бүтэц, тогтолцоог дахин тодорхойлох үүдийг нээснээр бидний хөгжил цэцэглэлт нь зөвхөн эдийн засгийн үзүүлэлтээр хэмжигдэх гэхээс илүүтэй манай гаригийн нийгмийн сайн сайхан байдал, эрүүл мэндийн нөхцөл байдлаар хэмжигдэх болжээ. Энэ нь эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад ач холбогдолтойгоос гадна Тогтвортой Хөгжлийн Зорилгуудад (ТХЗ) хүрэхэд амин чухал үүрэгтэй.

Гэсэн хэдий ч дэлхийн өнцөг булан бүрийн энтрепренер залуучууд ногоон болон нийгмийн бизнес эхлэх, өргөжүүлэхэд янз бүрийн томоохон саад бэрхшээлүүдтэй тулгарсаар байна.

Хөрөнгө оруулалтын шийдвэрүүд нь ихэвчлэн ашигт тулгуурласан байдаг нь ашгаас илүүтэй үр нөлөөг урьтал болгодог бизнесүүдийг сул талтай болгож байна. Үр нөлөөгөө хэмжих, баталгаажуулах нь бизнесээ шинээр эхэлж буй залуучуудад бэрхшээлтэй байж болно. Дэлхийн эдийн засгийн форумын мэдээлснээр, санхүү, чадавхийг бэхжүүлэх, зөвлөн дэмжих хүртээмж нь дэлхий даяар ихээхэн ялгаатай байгаа бөгөөд ялангуяа бага орлоготой орнуудад нийгмийн энтерпрайзуудын 15 хүрэхгүй хувь нь хангалттай санхүүжилт авах боломжоор хомс байдаг.

Энэхүү бодлогын зөвлөмжөөр дамжуулан Залуу Бизнесийн Олон Улсын Сүлжээ (YBI) болон тухайн сүлжээний Монгол улс дахь гишүүн Хөгжлийн Шийдэл ТББ-ын зүгээс хамтран залуучуудын ногоон болон нийгмийн бизнесийг илүү ихээр дэмжин ажиллахыг уриалж байна.



Танилцуулга

Ашгийг гол зорилгоо болгосон бизнесийн уламжлалт загварууд нь өнөөдөр бидний нүүрлэж буй нийгэм, байгаль орчны олон хямралд шууд хамааралтай.

Тогтворгүй үйл ажиллагаа, хог хаягдлын хэт их үйлдвэрлэл, хөдөлмөрийн мөлжлөгийн нөхцөл нь бохирдол, нөөцийн хомсдол, нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлыг улам гааруулсаар байна. Нөгөө талаас, олон бизнесүүд өөрсдийн боломж бололцоогоор өөрчлөлт шинэчлэлтийг эрэлхийлдэг. Тиймээс тэд байгаль орчныг хамгаалах, эдийн засгийн оролцоог дэмжих, нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх замаар эерэг нөлөө үзүүлэх хүчирхэг төлөөлөгч болж чадна гэдгээ харуулсаар байна.

Жишээлбэл, Зүүн Африкийн төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдоогүй айл өрхүүдийг нарны эрчим хүчээр ажилладаг системээр ханган, 1 сая гаруй өрхийг цахилгаантай болгосон Кенийн M-KOPA компанийг, мөн далай дахь хуванцар хаягдлыг зайлуулах дэвшилтэт технологи боловсруулан, 2040 он гэхэд далайд хөвж буй хаягдал хуванцарын 90%-ийг цэвэрлэх зорилттой The Ocean Cleanup зэрэг бизнесүүдийг дурдаж болно.

Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг биелүүлэхийн тулд, бизнесүүдийг амжилтаа зөвхөн санхүүгийн ашиг орлогоор бус, харин нийгмийн сайн сайхан байдал, дэлхийн эрүүл мэндэд оруулсан хувь нэмрээрээ дахин тодорхойлохыг шаардах боллоо. Тиймээс тогтвортой, тэгш ирээдүйг цогцлоохын тулд дэлхийн бизнесийн практикт яаралтай өөрчлөлт хэрэгтэй болж байна.

Энтрепренер залуучууд дэлхийн энэхүү өөрчлөлтийг удирдан чиглүүлэхэд хамгийн тохиромжтой. Дэлхий даяар маш олон залуучууд нийгэм, байгаль орчны асуудалд ихээр анхаарал хандуулж, өөрсдийн ажил үйлсээрээ утга учиртай нөлөө үзүүлэх хүсэл эрмэлзэлтэй байдаг.

Делойтте-ийн Z болон миллениал үеийнхнээс авсан 2024 оны судалгаагаар,



нь уур амьсгалын өөрчлөлтөд санаа зовж, ажил мэргэжлээ байгаль орчныг хамгаалахад чиглүүлж байгаагаа илэрхийлжээ.



2022 онд YBI-ийн захиалгаар Их Британийн энтрепренерүүдийн дунд хийсэн судалгаагаар, 35-аас доош насныхан 35-аас дээш насныхантай харьцуулахад бизнесийнхээ үндсэн зорилгыг нийгэм, байгаль орчны асуудлыг шийдвэрлэх тухай гэдгийг илэрхийлсэн нь даруй хоёр дахин илүү байсан бөгөөд тухайн судалгаанд оролцогч залуучуудын 40 гаруй хувь нь бизнесийн ашиг олохын тулд гаргах зардлаасаа хүн бүрийн ялгаатай байдлыг дэмжихэд болон нийгмийн сайн сайхны төлөө зарцуулахад голлон анхаардаг гэж хариулжээ.

Энтрепренер залуучууд эерэг өөрчлөлтийг бий болгох хүчтэй хүсэл эрмэлзэлдээ хөтлөгдөөд зогсохгүй нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэх шинэлэг санаачилга, шийдлүүдийг гаргадаг. Тэд уламжлалт арга барилд багахан баригдаж, илүү нээлттэйгээр байгаль орчин, нийгмийн асуудлуудыг үр дүнтэй шийдвэрлэх шинэ технологи, шинэ бизнесийн загваруудыг туршиж үзэх сонирхолтой байдаг. Дижитал эрин үед өсөн хөгжиж буй эдгээр энтрепренерүүд үр дүнтэй өөрчлөлтийг бий болгож, тогтвортой байдлыг дэмжихийн тулд нийгмийн сүлжээ, мэдээллийн шинжилгээ, тек-суурилсан бүтээгдэхүүн зэргийг ашиглан ямар ч технологиудыг чадварлагаар ашиглаж байна.

Мөн тэд урьд өмнөхөөсөө илүү дэлхийн түвшинд харилцан холбогдон, олон улсын асуудлуудыг мэддэг болсон нь тэдэнд хил хязгаарыг давсан сорилтуудыг ойлгож, шийдвэрлэх боломжийг олгож байна. Энэхүү дэлхийн чиг хандлага нь олон улсын хамтын ажиллагаа, өргөн цар хүрээтэй нөлөө бүхий шийдлүүдийг бий болгоход туслаж байна. Үүний зэрэгцээ энтрепренер залуучууд орон нутгийн иргэдтэйгээ нягт холбоотой байдаг нь тэдэнд тохирсон, тогтвортой шийдлээр тодорхой хэрэгцээг ойлгож, хариу өгөх боломжийг олгодог. Залуучуудын даяарчлагдсан ухамсар болон нутаг усны ойлголт хоорондын уялдааг бэхжүүлсэн өвөрмөц сэтгэлгээ нь тэднийг илүү тогтвортой ирээдүйг эрэлхийлэх эерэг өөрчлөлтийн хүчирхэг төлөөлөгч гэдгийг батлан харуулж байна.



Нийгмийн болон ногоон бизнесийг тодорхойлох нь

ҮБИ нь нийгмийн болон ногоон энтерпрайзыг хариуцлагатай, тогтвортой бизнесээс ялгаатайгаар авч үздэг.

Хариуцлагатай, тогтвортой бизнесийг үндсэн зорилгоос нь илүү арга барил, шийдвэр гаргах үйл явцаар тодорхойлдог. Энэ төрлийн бизнесүүд янз бүрийн салбарт үйл ажиллагаа явуулж, хууль ёсны бүх шаардлагыг дагаж мөрдөн, хүний эрх, зохистой хөдөлмөр эрхлэлтийн стандартыг баримталж, хүмүүс болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг идэвхтэй авч үздэг. Мөн тэд сөрөг үр дагаврыг бууруулж, бодитой эерэг үр дүнд хүрэхийг эрмэлздэг боловч гол анхаарал нь нийгэм, байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд чиглэдэггүй.



Харин эсрэгээрээ, нийгмийн болон ногоон энтерпрайзуудын хувьд эрхэм зорилгынх нь үндэс нь нийгэм, байгаль орчны тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэдэг.

ҮБИ-ийн хувьд дараахь шинж чанаруудыг тодорхойлдог:



Зорилгод тулгуурласан хандлага: Тэд угаасаа нийгэм, байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилготой бөгөөд энэ зорилго нь тэдний алсын хараа, эрхэм зорилгын гол цөм нь юм.



Нэгдмэл зорилго: Тэдний нийгмийн болон байгаль орчны зорилго нь алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, бизнесийн загварт бүрэн тусгагдсан байдаг.



Зорилгод тулгуурласан шийдвэр гаргалт: Нийгмийн болон байгаль орчны асуудлыг шийдвэрлэх эрхэм зорилго нь тэдний бизнесийн бүх түвшний шийдвэрт шууд нөлөөлдөг.

Нийгмийн болон ногоон энтерпрайзууд ашгийн бус эсвэл ашгийн төлөөх хуулийн этгээдийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болох хэдий ч, орлого, ашиг авчрах арилжааны хүчтэй үйл ажиллагаатай, үүгээрээ санхүүгийн хувьд маш тогтвортой байдгаараа онцлог.

Нийгмийн болон ногоон энтрепренершипт тулгарч буй саад, бэрхшээлүүд

Аливаа төрлийн бизнесийг эхнээс нь эхлүүлэх нь ялангуяа бизнесийн ертөнцөд шинээр орж буй залуучуудын хувьд олон сорилттой тулгардаг хүнд хэцүү даалгавар юм.

Ногоон болон нийгмийн зорилго бүхий бизнес эхлүүлэх нь өвөрмөц сорилтуудыг нэмж дагуулдаг, үүнд:



Санхүүжилтийн хүртээмж

Эхлэлийн хөрөнгөтэй болох нь олон энтрепренер залуучуудын хувьд томоохон сорилт. Нас залуу, туршлага бага учраас тэдэнд ихэвчлэн зээлийн түүх, барьцаа хөрөнгө, хөрөнгө оруулагч танилын хүрээ, зээл авахад шаардлагатай сүлжээ хангалттай байдаггүй. Ногоон, нийгмийн эрхэм зорилго бүхий нөлөөллийн бизнесүүд богино хугацаанд ашиг багатай, урт хугацаандаа хөрөнгө оруулалтын өгөөжтэй тул венчур хөрөнгө оруулалт болон уламжлалт банкны зээлд хамрагдахад илүү их бэрхшээлтэй тулгардаг. PwC-ийн мэдээлснээр

2023 онд уур амьсгалын технологийн салбарт венчур хөрөнгө оруулалт 50 тэрбум долларт хүрсэн ч энэ нь нийт санхүүжилтийн өчүүхэн хувийг эзэлж байна. Ногоон уур амьсгалын сан гэх мэт засгийн газар болон олон улсын дэмжлэг байдаг боловч энтрепренер залуучуудад хүртээмжгүй байдаг. Нэмж дурдахад хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хооронд санхүүгийн хүртээмжийн хувьд бүс нутгийн талаасаа томоохон ялгаа бий. Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (OECD)-ын гишүүн орнуудад санхүүгийн зах зээл төлөвшсөн, дэмжлэг, зохицуулалтын орчин тодорхой тул ногоон санхүүжилт илүү хүртээмжтэй байдаг. Эсрэгээрээ, 2023 оны Уур амьсгалын бодлогын санаачлагын тайланд дурдсанаар, Африкийн ногоон бизнесүүд дэлхийн уур амьсгалын санхүүжилтийн тав хүрэхгүй хувийг авсан байна. UNCTAD-ийн 2023 оны Дэлхийн хөрөнгө оруулалтын тайланд ТХЗ-ыг биелүүлэхийн тулд хөгжиж буй орнуудад жил бүр 3 их наяд ам. долларын нэмэлт хөрөнгө оруулалтын хэрэгцээ байнга гарч байгааг онцолсон бөгөөд энэ нь жил ирэх тусам өсөх хандлагатай юм. Санхүүжилтийн асуудлаас гадна, байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг чухалчлан үздэг бизнесүүд зөвхөн

ашгийн зорилготой бизнесүүдтэй харьцуулахад, тогтвортой орлого олохын тулд илүү урт хугацааг туулдаг.



Зах зээлд нэвтрэх, хүлээн зөвшөөрүүлэх нь

Удаан хугацаанд оршин тогтносон брэндүүдэд үнэнч хэрэглэгчийн зах зээлд байгальд ээлтэй болон нийгмийн хариуцлагатай бүтээгдэхүүнээр нэвтрэх нь хэцүү байдаг. Ногоон болон нийгмийн гарааны бизнесүүд, олон жил танигдсан, томоохон компаниудын адил зах зээлд хүлээн зөвшөөрүүлэх маркетингийн төсөвтэй байдаггүй. Хэрэглэгчийн зан төлвийг өөрчлөх нь бас томоохон сорилт юм. Deloitte-ийн 2023 оны тайланд хэрэглэгчдийн 65% нь байгальд ээлтэй бүтээгдэхүүнийг илүүд үздэг бол ердөө 30% нь тогтвортой байдлын зарчимд тулгуурлан худалдан авах шийдвэрээ байнга гаргадаг болохыг онцолсон байна. Үүний шалтгаан нь үнийн мэдрэмж, хэрэглэгчдийн үл итгэх байдал юм. Ногоон бүтээгдэхүүн нь ихэвчлэн өндөр үнээр бүтдэг бөгөөд энэ нь олон хэрэглэгчдэд хүрэхэд саад болдог. Олон улсын худалдааны төвөөс (ITC) 2022 онд хийсэн судалгаагаар

үнийн мэдрэмж нь тогтвортой бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд ихээхэн саад болж байгаа бөгөөд хэрэглэгчдийн 55% нь ногоон тодотголтой бүхэнд илүү үнэ төлөх хүсэлгүй байгааг онцолжээ.



Бодлого, зохицуулалтын асуудал

Нарийн төвөгтэй, тодорхойгүй зохицуулалтын хүрээнд ажиллах нь ногоон болон нийгмийн энтрепренерүүдэд томоохон сорилт болдог. Тохиромжгүй хууль эрх зүйн тогтолцоо, хүнд суртал, тууштай бус бодлого нь тэдний бизнесийн үйл ажиллагааны үр ашгийг бууруулж, шаардлагатай нөөцийн хүртээмжийг хязгаарлаж болзошгүй юм. Ногоон болон нийгмийн энтерпрайзуудыг хуулийн этгээдээр хүлээн зөвшөөрөх, тэдний өсөлт, хөгжил, үр нөлөөг бий болгох таатай орчныг бүрдүүлэхэд тодорхой хууль эрх зүйн зохицуулалт нэн чухал юм.



Нийлүүлэлтийн сүлжээний сорилтууд

Бизнесийнхээ ногоон болон нийгмийн бүхэл зорилгыг хадгалахын тулд энтрепренер залуучууд нийлүүлэлтийн сүлжээний бүхий л үе шатанд байгаль орчин, нийгмийн стандартыг дагаж мөрдөх ёстой. Гэвч үүнийг

гүйцэтгэхэд нэлээд сорилттой, мөн зардал өндөртэй. Deloitte-ийн 2023 оны судалгааны тайланд компаниудын 64 хувь нь ил тод бус байдал, мөшгих чадавхгүйгээс нийлүүлэлтийн сүлжээн дэх байгаль орчин, нийгмийн стандартыг даган мөрдөж, баталгаажуулахад бэрхшээлтэйг онцолсон байна. Дэлхийн Эдийн Засгийн Форумаас (WEF) 2022 онд явуулсан судалгаанд хамрагдсан бизнесүүдийн 70 хувь нь нийлүүлэлтийн сүлжээгээ байгаль орчин, нийгмийн стандартад нийцүүлэхтэй холбоотойгоор зардал нь нэмэгдсэн гэж мэдэгджээ. Бизнесүүд шинэлэг арга барил, нэмэлт эх үүсвэрийн дэмжлэгтэйгээр зах зээлийн эрэлтийг хангах замаар өсөн хөгжих тусам байгаль орчинд ээлтэй, ёс зүйтэй ханган нийлүүлэлтийн сүлжээгээ хадгалахад улам хэцүү болж байна.



Нөлөөллийг хэмжих, харуулах

Бизнесийнхээ байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг үр дүнтэйгээр хэмжиж, бодитойгоор харуулах нь ногоон болон нийгмийн энтрепренерүүдийн хувьд хөрөнгө оруулагчид болон үйлчлүүлэгчдийг татахад чухал ач холбогдолтой боловч маш их сорилт, бэрхшээлтэй ажил юм. Нөлөөллийг хэмжих стандартчилсан хэмжүүр байхгүйгээс харьцуулалт хийх, найдвартай байдлыг хангахад улам хүндрэлтэй болдог.

Олон байгууллагууд өөрсдийн тодорхойлсон хүрээ, жишиг үзүүлэлтүүдийг ашигладаг нь аливаа нөлөөллийн үр дүнг компаниуд хооронд эсвэл салбарын түвшинд харьцуулахад төвөгтэй болгож байна. Энэхүү үл нийцэл нь нөлөөллийн тоо баримтын найдвартай байдлыг алдагдуулж болзошгүй юм. Нэгдсэн стандарт байхгүйгээс оролцогч талууд янз бүрийн нөлөөллийн аргуудыг үнэлэх, харьцуулах боломжгүй гэсэн үг. UK Social Enterprise-ийн судалгаагаар нийгмийн энтерпрайзуудын 60 хувь нь нийгэм, байгаль орчинд бий болгож буй нөлөөллөө хэмжих, баталгаажуулахад бэрхшээлтэй тулгардаг гэж мэдээлсэн нь санхүүжилт, дэмжлэг авах чадварт нь давхар нөлөөлж байна. Ногоон болон нийгмийн энтрепренер залуучууд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх хүсэлтэй ч шаардлагатай нөөц боломж, туршлагаар дутагддаг. Энэхүү бэрхшээл нь өндөр өртөгтэй, ашиглахад төвөгтэй тусгай хэрэглэгдэхүүн, аргачлал шаардлагуудаас ихэвчлэн бий болдог.

60

хувь нь нийгэм, байгаль орчинд бий болгож буй нөлөөллөө хэмжих, баталгаажуулахад бэрхшээлтэй тулгардаг гэж мэдээлсэн нь санхүүжилт



ҮБІ ногоон болон нийгмийн энтрепренершипийн багц хэрэглэгдэхүүн

Ногоон болон нийгмийн энтрепренер залуучуудад тулгарч буй сорилтууд болон тэдэнд тохирсон дэмжлэг зайлшгүй шаардлагатай байгааг авч үзсэний үр дүнд, ҮБІ нь Африк, Ази, Европ, Карибын тэнгисийн орнуудаас есөн гишүүн байгууллагуудтайгаа (энтерпрайзуудыг дэмжин, хөгжүүлэгч) хамтран Ногоон болон Нийгмийн Энтрепренершипийн багц хэрэглэгдэхүүнийг боловсруулан танилцуулсан.

Энэхүү багцыг ногоон болон нийгмийн энтрепренерүүдийг дэмжихэд юу болж, юу болохгүй байгаа тал дээр ҮБІ болон гишүүдийн мэдлэг, туршлагаар баяжуулан хөгжүүлж, энэ чиглэлээр дэмжлэг үзүүлэх сонирхолтой энтерпрайзуудыг дэмжигч байгууллагуудад (ESOs) зориулсан. Дөрвөн тивийн ҮБІ-ийн гишүүдтэй хамтран бүтээсэн уг багцыг янз бүрийн улс орны нөхцөлд ажиллаж буй ногоон болон нийгмийн энтрепренер залуучуудад байнгын хэрэгцээтэй, ашиглагдахуйц байлгахад анхаарсан.

Энэхүү багцад дараах зургаан үндсэн чиглэлийн хэрэглэгдэхүүнийг эмхэтгэн оруулсан:

- 1 Хувь хүний хөгжил, өөрийгөө танин мэдэхүй
- 2 Бизнес ба нөлөөллийн санаа
- 3 Бизнес загвар
- 4 Бизнесийн баталгаажуулалт
- 5 Хууль эрх зүй, засаглал, санхүү
- 6 Нөлөөллийн хэмжилт ба өсөлт

Монгол улсад бизнес эрхлэх хүсэлтэй энтрепренерүүдэд ур чадвар олгох сургалт, эхлэлийн санхүүжилт, менторинг, зөвлөгөө өгөх зэрэг бизнесийг дэмжих цогц үйлчилгээгээр ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулдаг Хөгжлийн Шийдэл ТББ нь ҮБІ сүлжээний гишүүн байгууллага бөгөөд ногоон болон нийгмийн энтрепренершипийн багц хэрэглэгдэхүүнийг хамтран боловсруулж, туршилтын сургалт, менторинг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.



🔍 Монгол улсын тухай товчхон


Монгол Улсад залуучуудын энтрепренершип туршлага мэдэгдэхүйц өсөн нэмэгдэж байгаа бөгөөд улс орны тогтвортой хөгжилд гол хөдөлгөгч хүч болж байна.

15-34 насны залуучууд нь Монгол Улсын нийт хүн амын бараг гуравны нэгийг эзэлж байгаа нь залуучууд төвтэй эдийн засаг, нийгмийн хөгжил дэвшлийн асар их нөөц бололцоо байгааг харуулж байна. Нийгмийн энтрепренершип нь ялангуяа Монголчуудын соёлын өв, тэр дундаа 13-р зуунаас хойшхи нийгэм-эдийн засгийн хувьсал, өөрчлөлттэй салшгүй холбоотой.

Монголын эзэнт гүрний Их засаг хууль нь хамтын хариуцлага, шударга ёс, нөөц баялгийн зохистой ашиглалтыг зохицуулах талаасаа өнөө цагийн нийгмийн энтрепренершипийн зарчмуудтай шууд уялддаг. Нүүдэлчин соёл уламжлал, Торгоны замын худалдааг агуулсан хосолмол эдийн засаг нь нийгэм, ногоон хөгжлийг дэмжсэн бараа бүтээгдэхүүн, санааны солилцоог хөхүүлэн дэмжиж байв. Худалдааны Каравансарай төвүүдэд олон нийтийн оролцоо, хүртээмжтэй төрийн бодлогыг хэрэгжүүлж байсан нь өнөөгийн нийгмийн энтрепренершипийн экосистемийн хөгжилд чухал ач холбогдолтой болсон.



Өнөөдөр Монгол улсад байгаль орчин, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд ногоон болон нийгмийн бизнесийн шинэлэг шийдлүүд нэн шаардлагатай байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс болж агаарын дундаж хэм огцом нэмэгдэж, цөлжилт, бэлчээрийн доройтол, усны хомсдол, цаг агаарын эрс тэс үзэгдлийн давтамж илүү ажиглагдах болов. Үүний зэрэгцээ Монгол Улсад ядуурал чухал асуудал хэвээр байна.



Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2023 оны улс орны тоон баримтаас харахад, нийт хүн амын **27.8** хувь нь ядуурлын түвшнээс доогуур амьдарч байна.

Хот, хөдөөгийн ялгаа илт ажиглагдаж, хөдөөгийн хүн амын эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн суурь үйлчилгээг хүртэх боломж тааруу хэвээр байна. Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооноос гаргасан судалгаанд өгүүлсэнээр, хөдөө сумын амьжиргаа улам бүр даашгүй болж, хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн ихсэж, олон мянган залуучууд хотод илүү сайхан амьдрах боломжийг эрэлхийлэн гэр орон, нутгаа орхин явсаар байна.

Нийгмийн сайн сайхан байдал, эдийн засгийн өсөлт, байгаль орчны тогтвортой байдал, соёлыг хамгаалах зорилгоор НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2023 оны 4 дүгээр сард баталсан “Тогтвортой хөгжлийн төлөө нийгэм, эв нэгдлийн эдийн засгийг дэмжих тухай” НҮБ-ын тогтоолыг Монгол Улс бусад нэр бүхий гишүүн орнуудын хамт санаачлан батлуулсан. Энэхүү хариуцлагатай үйлдлээрээ Монгол Улс нь нийгмийн энтрепренершип зарчмуудыг үндэсний бодлогодоо тусган, тогтвортой хөгжил болон зорилтот бүлгийн залуучуудыг зохистой хөдөлмөр эрхлэх боломжуудаар хангахад анхааран ажиллаж байна.

Гэсэн хэдий ч, Монгол улсад ногоон болон нийгмийн энтрепренер залуучууд томоохон саад бэрхшээлтэй нүүр тулсаар байна. Сүүлийн жилүүдэд Монголбанк бодлогын хүүг 15 хувьд хүргэснээр арилжааны банкуудын зээлийн хүү өндөр хэвээр байх нөхцлийг бүрдүүлж, залуу бизнес эрхлэгчдэд бизнесээ өргөжүүлэхэд боломжийн нөхцөлтэй зээл авахад хүндрэл учруулж байна.

Зарим улс орон нийгмийн болон ногоон энтрепрайзуудад бага хүүтэй санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг санал болгодог бол Монгол улсад байдал өөр байна. Ногоон болон нийгмийн энтрепрайзуудад зориулсан санхүүжилт дутмаг байгаа нь энэ асуудлыг улам бүр хүндрүүлж байна. Мөн ногоон бүтээгдэхүүний зах зээл өсөн нэмэгдэж байгаа боловч бүгдэд шинэ ойлголт хэвээр байгаа нь зах зээлд шинээр орж ирж буй бизнесүүдэд өөрийн байр сууриа тогтоох, томоохон хэрэглэгчийн баазыг татахад бэрхшээлтэй байна. Түүнчлэн, нийгмийн болон байгаль орчны зорилгыг ашиг орлоготой ижил түвшинд авч үзэж сурах нь гол асуудал хэвээр байна. Монгол улсад тогтвортой хөдөө аж ахуйн салбарын болон байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг олон нийгмийн болон ногоон энтрепрайзууд нийгэм, байгаль орчны эрхэм зорилгоо биелүүлэхийн зэрэгцээ санхүүгийн тогтвортой байдалд хүрэхэд хэцүү байна.




Хөгжлийн Шийдэл ТББ-ын ногоон болон нийгмийн энтрепренершипийн багц хэрэглэгдэхүүнтэй туршилтын сургалт

Дээр дурдсан асуудал, бэрхшээлүүдийг шийдвэрлэхийн тулд YBI-ийн Монгол улс дахь гишүүн Хөгжлийн Шийдэл ТББ нь YBI-ийн ногоон болон нийгмийн энтрепренершипийн багц хэрэглэгдэхүүнийг боловсруулахад, ялангуяа нийгмийн энтерпрайзын санхүүжилтийн загвар, санхүүгийн менежментийн талаарх хэсэг дээр голчлон хувь нэмрээ оруулан оролцсон.

2023 оны 5-р сард Хөгжлийн Шийдэл ТББ нь тогтвортой хөгжлийг дэмжих нийгмийн зорилго бүхий энтрепренер залуучууд болон гарааны бизнес эрхлэгчдийг чадавхжуулах туршилтын сургалтыг эхлүүлсэн.

Нийт хоёр удаагийн элсэлтээр Улаанбаатар хот болон 14 аймгаас 200 гаруй оролцогчид танхимын сургалт, цахим менторинг, видео сургалтад тус тус хамрагдсан.



Сургалтын хөтөлбөр үндсэн зургаан модультай бөгөөд төгсөгчдийн зүгээс өөрийгөө тодорхойлох дасгал, нийгмийн бизнес загвар, санхүүжилтийн боломжоо тодорхойлох хэрэглэгдэхүүн хамгийн их сонирхол татахуйц байсныг онцолсон. Эдгээр хэрэглэгдэхүүн нь өөрсдийн оновчтой бизнес загварыг бий болгох, бизнесээ ямар шатандаа явж байгааг, өөрт тохирох ямар төрлийн санхүүжилт хайж буй, энэ төрлийн санхүүжилтэд хүрэхийн тулд хэрхэн бэлдэх зэрэг мэдлэгийг олгодог. Үүний үр дүнд, сургалт, менторингийн үйл ажиллагаанд хамрагдсан оролцогчдоос 23 энтрепренер буцалтгүй тусламжаас эхлээд хөнгөлөлттэй зээл зэрэг олон төрлийн эх үүсвэрээс нийт 500 гаруй мянган ам.долларын санхүүжилт олж авав. Энэхүү санхүүгийн дэмжлэг нь тэдэнд нийгмийн зорилгоо биелүүлж, ногоон бизнесийн дадлаа сайжруулах боломжийг олгосон.

Ийнхүү хэрэгжсэн цуврал сургалт, менторингийн арга хэмжээний төгсгөлд Хөгжлийн Шийдэл ТББ Монгол орны өнцөг булан бүрээс 150 гаруй нийгмийн болон ногоон энтрепренерүүдийг урьж, өөрсдийн бизнес

загвар, үр нөлөөний талаар харилцан туршлага хуваалцсан Нийгмийн Энтрепренершип Чуулган 2023-ыг зохион байгуулсан. Мөн 50 нийгмийн энтерпрайз өөрсдийн нийгэм, байгаль орчны эерэг үр дүнгээ харуулсан үзүүлэнг бэлтгэн, холбогдох төрийн байгууллага, санхүүгийн байгууллага, иргэний нийгмийн төлөөллүүд болон бусад нийгмийн, ногоон бизнесүүддээ танилцуулсан. Энэхүү үйл явдал нь зөвхөн оролцогч талуудын сонирхлыг төрүүлээд зогсохгүй, Монгол улсад нийгмийн энтерпрайзуудыг өргөжин хөгжүүлэхэд дэмжих бодлого, тогтолцоо чухал шаардлагатай байгааг онцлохын зэрэгцээ, нийгмийн сорилтуудыг даван туулах, эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад энтрепренершипийн үүрэг, оролцооны талаарх ойлголтыг өгөв.

Чуулганы үр дүнд, нийгмийн энтерпрайзуудын хууль эрх зүйн тодорхой орчин, сүлжээг бий болгох зорилготой Монголын Нийгмийн Энтерпрайзуудын Холбоог байгуулах санаачилгын эхлэл тавигдсан.



150



гаруй нийгмийн болон ногоон энтрепренерүүдийг урьж, өөрсдийн бизнес загвар, үр нөлөөний талаар харилцан туршлага хуваалцсан Нийгмийн Энтрепренершип Чуулган 2023-ыг зохион байгуулсан.



50



нийгмийн энтерпрайз өөрсдийн нийгэм, байгаль орчны эерэг үр дүнгээ харуулсан үзүүлэнг бэлтгэн, холбогдох төрийн байгууллага, санхүүгийн байгууллага, иргэний нийгмийн төлөөллүүд болон бусад нийгмийн, ногоон бизнесүүддээ танилцуулсан.



Кейс судалгаа:

Эрдэнэбаярын Аръяабазарын санаачилга



Кейс судалгаа: Эрдэнэбаярын Аръяабазарын санаачилга

Монгол улсын хойморьт орших Хөвсгөл нуурын эрэг дээр үйл ажиллагаа явуулдаг Аръяа кафе нь зүгээр нэг кофешоп биш юм; ялангуяа алслагдмал нутгийн хүүхэд, залуучуудын нийгэмших, мэдлэг боловсролтой болгоход дэмжих чухал төв юм.

Тус бизнесийг үүсгэн байгуулагч 32 настай Эрдэнэбаярын Аръяабазар эх нутагтаа тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг түгээх замаар залуучуудын боловсрол, соёлыг хөгжүүлэх зорилгыг өвөртлөн ажиллаж, амьдарч байна.

Хөгжлийн Шийдэл ТББ-аас зохион байгуулсан сургалт, менторингийн арга хэмжээнд хамрагдсан тэрээр кофешоптоо нийгмийн бизнесийн шинэлэг загварыг нэвтрүүлэн хэрэгжүүлэхдээ бичил тэтгэлэг болон хөнгөлөлттэй зээл авсан. Үүгээр зөвхөн үйл ажиллагаагаа сайжруулаад зогсохгүй нийгэмд чиглэсэн үлгэр жишээ ажлуудаа улам өргөжүүлсээр байна.

Аръяа кафе нь байгуулагдсан цагаасаа хойш нийт 1,200 хүүхдийг сургуулиас гадуурх боловсролын хөтөлбөрөөр дэмжиж ирсэн. Тус кафе нь хэлний мэдлэгийг дээшлүүлэх англи хэлний ярианы клуб болон ном унших клубыг санал болгож, нутгийн залууст том мөрөөдөж, шинэ боломжуудыг судлах орчныг санал болгодог.

Аръяа кафе нь залуучуудын боловсрол, чадавхид анхаарахын зэрэгцээ тогтвортой байдлын төлөө ажилладаг. Бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ үйл явцыг байгальд ээлтэйгээр шийдэж, өөрийн кофены аягаа авчирсан үйлчлүүлэгчдэд хөнгөлөлт үзүүлэх гэх мэт тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах арга барилыг хэрэгжүүлснээр тус кафе нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөө багасгаж, нийгэмдээ үлгэр дуурайлал үзүүлж байна.

Аръяа кафе нь уугуул хүүхдүүд болон тэдний гэр бүлийн амьдралд байнгын өөрчлөлтийг авчирч байна. Ийнхүү залуу эзэнтэй нийгмийн энтерпрайзуудад оновчтой, бодит дэмжлэг үзүүлж чадвал илүү гэрэлт ирээдүйг бүтээхэд хэрхэн нөлөөлж болохын тод жишээ юм.



Зөвлөмж

Залуу Бизнесийн Олон Улсын Сүлжээ (YBI) болон Монгол улс дахь гишүүн Хөгжлийн Шийдэл ТББ нь илүү олон залуучуудыг ногоон болон нийгмийн бизнесийг эхлүүлэх, өргөжүүлэхэд нь дэмжин туслах зорилгоор засгийн газар, санхүүгийн байгууллага, хөгжлийн байгууллагуудад дараах нэгдсэн зөвлөмжийг хүргэж байна:

1

Энтрепренер залуучуудад зориулан төрийн дэмжлэгтэй, олон улсын залуучуудад чиглэсэн ногоон болон нийгмийн хөрөнгө оруулалтын сангуудыг бий болгож, ногоон болон нийгмийн энтерпрайз эрхэлдэг энтрепренер залуучуудыг дэмждэг хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт болон татаас олгох боломжоор хангах, түүнчлэн, ногоон болон нийгмийн энтрепренер залуучуудыг дэмжих чиглэлээр мэргэшсэн байгууллагуудад зориулсан санхүүжилтийн тогтолцоог бий болгох;

2

Нийгэм, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бизнесүүдэд татаас болон татварын хөнгөлөлт үзүүлэх нь ногоон үйлдвэрлэлтэй холбоотой өндөр зардлыг бууруулах, ялангуяа залуу удирдлагатай жижиг бизнесүүдэд ногоон шошго, эко тэмдэг авах үйл явцыг хялбаршуулах;

3

Ногоон болон нийгмийн энтерпрайзыг дэмжих тууштай орчинг бүрдүүлэхийн тулд улс орны онцлог, нөхцөлд тохирсон хууль эрх зүйн орчинг боловсруулж, зохицуулалтын үйл явцыг оновчтой болгох;

4

Энтрепренер залуучуудыг ханган нийлүүлэлтийн сүлжээнд ил тод байх, байгаль орчин, нийгмийн стандартыг дагаж мөрдөхөд нь туслах арга барил, урамшуулал, түншлэлээр хангах;

5

Нөлөөллийн хэмжилтийн стандартчилсан тогтолцоог боловсруулан олон нийтэд таниулах, энтрепренер залуучуудыг байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг үр дүнтэй хэмжих, дамжуулахад шаардлагатай сургалт, санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх;

6

Боловсролын хөтөлбөрт ногоон болон нийгмийн энтрепренершип ур чадварыг хөгжүүлэх агуулгыг тусгаж, ногоон болон нийгмийн энтерпрайзуудын талаарх мэдээллийг тогтмол цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах стратегийг батлах.





www.youthbusiness.org



[Youth Business International \(YBI\)](https://www.linkedin.com/company/youth-business-international)



[/youthbusiness](https://www.facebook.com/youthbusiness)



[@YouthBizInt](https://twitter.com/YouthBizInt)



[@youthbizint](https://www.instagram.com/youthbizint)